



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/576

Улаанбаатар хот

Хууль, тогтоолын биелэлтийг
зохион байгуулах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.1.1, 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.10 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн 11.12 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зар сурталчилгааны тухай, Зөвшөөрлийн тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 9/10 дугаар тогтоолын биелэлтийг хангах зорилгоор нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах, хүчингүй болгох арга хэмжээг дараах нутаг дэвсгэрийн харьяаллаар зохион байгуулан ажиллахыг доор дурдсан албан тушаалтанд даалгасугай:

1.1.Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр);

1.2.Багануур, Багахангай, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт тухайн дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нар.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202819